

АНУ ДАХЬ ОРЧИН ҮЕИЙН ХЯТАДЫН СУДАЛГАА, ТҮҮНИЙ ХӨГЖИЛ

*Д. Шүрхүү**

1950-иад оны эцэс хүртэл АНУ-д орчин үеийн Хятад орныг судлах ажил хөрөнгө мөнгө, боловсон хүчний дутагдал мөн түүнчлэн 1949 онд БНХАУ байгуулагдаж коммунист засаглал тогтсоны улмаас Хятадад очиж судалгаа хийх боломжгүй болсон төдийгүй судалгааны байгууллагын гадаад харилцаанд улс төрийн тааламжгүй орчин үүссэнтэй холбогдон зогсонги байдалд байсан юм. Харин 1959 онд АНУ-ын Судлаачдын зөвлөл /Council of Learned Societies/ болон Нийгмийн ухааны судалгааны зөвлөл /Social Science Research Council/ Фордын сангийн дэмжлэгтэйгээр орчин үеийн Хятадыг судлах хамтарсан хороо /Joint Committee on Contemporary China/ байгуулагдаж, орчин үеийн Хятадын эдийн засаг, улс төрийн систем, нийгмийг судлах өргөн хүрээтэй төслүүдийг АНУ-ын засгийн газар, Фордын сангаас санхүүжүүлж эхэлсэн юм. Орчин үеийн Хятад орныг судалсан нөхцөл байдал, судалгааны чиг хандлага, арга барил, үр дүн зэргийг харгалзан АНУ-ын Хятад судлалыг тус бүр арван жилийг хамарсан гурван үе шатанд хувааж болох байна. Тухайлбал 1960-аад оны үед Америкийн хятад судлаачид хувьсгалын дараахь Хятад орны нийгэм, улс төр, эдийн засгийн байдлыг хятадын хэвлэл болон хятад цагаач иргэдийн ярилцлагыг нягтлан судлах замаар судалж байсан бол 1970-аад онд соёлын хувьсгалын үүсэл, шалтгаан, үр дагаврыг судлахын зэрэгцээ Хятад судлалыг өргөжүүлэх, дагнасан, бүсчилсэн байдлаар явуулж байв. 1980-аад онд Америкийн эрдэмтэд Хятадад очиж судалгаа явуулах шинэ боломж гарч ирсний үр дүнд Хятадын хот хөдөө, үйлдвэр аж ахуйн газрын үйл амьдралд гүнзгий судалгаа явуулсны сацуу Маогийн дараахь үеийн Хятад дахь шинэтгэлийн шалтгаан, үйл явцыг нарийвчлан судлах болов. Дээрх гурван үе шат бүрд Америкийн хятад судлаачид нийгмийн амьдралд янз бүрийн үүрэг гүйцэтгэж байлаа. 1960-аад онд хятад судлаачид судалгааны орчин, дэд бүтцийг байгуулахын зэрэгцээ хятадын талаархи мэдлэгийг олон түмэнд түгээх ажилд оролцож, АНУ-аас Хятадтай хэрхэн харилцах талаархи маргааныг ард олны дунд явуулахад идэвхтэй оролцож байлаа. 1970-аад оны Америкийн судлаачид хятад судлалын салбарын

* Д.Шүрхүү- доктор PhD

томоохон зорилтуудыг хэрэгжүүлэхийн зэрэгцээгээр нэг хэсэг нь дайны эсрэг хөдөлгөөнд, нөгөө хэсэг нь засгийн газрын Хятадтай харилцах бодлого боловсруулах үйл явцад оролцож, үлдэх хэсэг нь нийтийн боловсрол олгох үндэсний байгууллагууд бий болгох. Хятадтай соёлын солилцоо, судалгааны салбарт хамтын ажиллагааг хөгжүүлэх чиглэлээр ажиллаж байлаа. 1980-аад онд эрдэм мэдлэг түгээн дэлгэрүүлэх, бодлого хэлэлцэх асуудалд бага анхаарч судалгааны ажилд хүч анхаарлаа төвлөрүүлэн хятад эрдэмтэдтэй эрдэм шинжилгээний талаар хамтран ажиллах ихээхэн хүсэл сонирхолтой байлаа. АНУ дахь Хятад судлалын хөгжилд тухайн үеийн хоёр орны дотоод улс төрийн байдал, Хятадын дотоод нийгэм, улс төрийн байдлаас үүдэн америкийн судлаачид өөрийн судалгааг коммунист дэглэм, "Их үсрэлт", "Соёлын хувьсгал", шинэтгэл, Тяньаньмэний хэрэг явдал гэсэн байдлаар явуулж байна. АНУ дахь нөхцөл байдал ч судалгааны ажилд мөн их нөлөөтэй байлаа. Засгийн газар, олон нийтийн сангуудаас хятад судлалыг санхүүжүүлэх сонирхлын өсөлт бууралт нь түүний хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйлийн нэг юм. Тийм ч учраас бууралтыг гагцхүү үүгээр тайлбарлаж болно. Америкийн хятад судлалд нөлөөлөх бас нэгэн хүчин зүйл бол АНУ-ын Их сургуулиудын төлөв байдал юм. Одоо дээр дурдсан гурван үе шатыг тус бүрд нь авч үзье.

Нэгдүгээр үе шат: 1960-аад он

1950-аад оны үед Хятадын уламжлалт гүн ухаан, сүүлчийн эзэнт улсын улс төрийн тогтолцоо, гадаад харилцаа болон коммунист хөдөлгөөний үүсэл зэрэг чиглэлээр хэд хэдэн сайн бүтээлүүд гарсан боловч 1949 оноос хойшхи Хятадыг судлах ажил АНУ-д 10 жилээр хойшлогдсон юм. Харин 1950-аад оны сүүлч 1960-аад оны эхэн үед хятад судлал сэргэн хөгжихөд нэлээд хэдэн хүчин зүйлс нөлөөлжээ. Юуны өмнө АНУ-д дээд боловсрол маш хурдан хөгжиж, их дээд сургуулиуд мэргэжилтэн бэлтгэх болон судалгааны ажлын цар хүрээг өргөжүүлэх шаардлага бий болсон. Мөн энэ үед нийгмийн ухаан ид цэцэглэн хөгжиж, шинэ шинэ салбарууд ялангуяа гуравдахь ертөнцийн эдийн засгийн шинэчлэлт, улс төрийн хөгжилтөнд зориуд анхаарал тавьж байлаа. Мэдээж энэ үед Хятад судлал холбооны засгийн газар болон Фордын сан /1950, 60-аад оноос эхлэн/ 1958 онд Үндэсний батлан хамгаалах боловсролын /National defence education act/ тухай хууль батлагдсанаас эхлэн аль алианаас нь илүүтэй дэмжлэг хүлээх болсон юм. Оюутны сургалт, судалгааны төсөл, эрдэм шинжилгээний бага

хурлыг санхүүжүүлэх асуудлыг дээр дурдсан хамтарсан хороо зохицуулж байв. Эхний үе шатан дахь судалгааны гол сэдэв бол Хятад дахь коммунист шинэ дэглэм, түүний нийгэм дэх нөлөө тухайлбал хятадын хүнд сурталт засаглал, түүний байгууллагуудын үйл ажиллагаа, хятадын коммунист номлол, түүний хэрэгжилт, эдийн засгийг хөгжүүлэх стратегийн хувьсал, өөрчлөлт зэрэг болно. Тэр үеийн хятад судлалын нэг бэрхшээл бол Хятад орны хаалттай байдлаас үүдсэн мэдээллийн хомсдол бөгөөд үүний улмаас судалгааг зайнаас явуулж байлаа. Хятадын албан ёсны хэвлэл мэдээлэл судалгааны гол эх сурвалж байсан боловч тэдгээр нь гол төлөв нэг хэвийн, мэдээллийн ач холбогдлоор лутмаг байлаа. Ялангуяа "Их үсрэлт"-ийн бодлого дампуурсны дараа албан ёсны эдийн засгийн тоо баримт гадаадынханд олж авахад маш хүнд болсон юм. Энэ үед Америкийн судлаачид Гонгконг-д ирсэн хятад иргэдээс маш чухал мэдээлэл олж авдаг байлаа. Тэр ч байтугай орчин цагийн хятадын тууж өгүүлэгийг Хятадын нийгмийн байдлыг судлах түлхүүр болгон ашиглах явдал гарч байсан ажээ. Хэдийгээр энэ үед саад бэрхшээл, тулгалт байсан боловч Америкийн хятад судлаачид орчин үеийн Хятадын талаархи тойм байдлыг амжилттай бий болгож чадсан юм. Тэд мөн судалгааг амжилттай хийхийн зэрэгцээ нэгэнт олдсон боломж цаг үеийг ашиглан судалгааны бүтцийг бий болгож, бааз сууриа бэхжүүлж чадсан нь өнөөг хүртэл хадгалагдсаар байна. Юуны өмнө Харвард, Колумб, Мичиган, Вашингтон, Калифорни, Стенфорд зэрэг их сургуулиудын дэргэд хятад судлалын томоохон төвүүдийг байгуулав. Зарим судлаачид орчин үеийн Хятадыг судлах хамтарсан хорооны гишүүнчлэлээрээ дамжуулан хятад судлалын чиглэлийн оюутны сургалтыг дэмжих, судалгааны төсөл санхүүжүүлэх эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зэргээр салбарын үйл ажиллагааг зохицуулж байлаа. Мөн энэ үед АНУ-аас санхүүжүүлсэн 3 байгууллага, Англид "China Quaterly" хэмээх салбарын тэргүүлэх сэтгүүл, Тайбэйд хятад хэл сургалтын голлох төв, Гонгконгт их сургуулиудын зохицуулах төв буюу баримт судлал болон цагаач иргэдээс авсан ярилцлага судлах төвүүд байгуулагдсан юм.

АНУ дахь орчин үеийн хятад судлалын эхний үе шат олон арван судалгааны төвүүд гэх мэт зохион байгуулалтын маргашгүй өв үлдээж, судалгааны томоохон амжилт авчирсан боловч дор дурдсан 3 гол дутагдал илэрсэн юм. 1-рт мэдээллийн эх сурвалж хязгаарлагдмал байснаас шалтгаалан гол гол судалгаа хэтэрхий ерөнхийлсөн байдалтай, улс орныг бүхэлд нь хамарсан шинжтэй байв. 2-рт хятадын

хэвлэлд хэтэрхий түшиглэх хандлага юм. Эхэн үеийн судалгаанд улс төрийн байгууллагуудын бүтцийг хэлбэрийн талаас үзэл суртал, төрийн бодлогын бүрдэл хэсгийг судлах ажил зонхилж, харин төрийн тогтолцоо хэрхэн ажиллаж байсан, жинхэнэ удирдагчид болон бодлогыг хэрхэн боловсруулж байсан, тэр нь нийгэмд хэрхэн нөлөөлж байсныг судлах явдал орхигдсон байв. Эцэст нь орчин үеийн Хятадыг судлахдаа түүхэн, харьцуулсан концепцийн нөхцөл байдлаас салангид авч үзсэн байна. Чухамдаа анхдугаар таван жилийн төлөвлөгөө, "Их үсрэлт"-ийн бодлогыг судлахдаа коммунист засаглалтай орнуудтай харьцуулах, коммунист өөрчлөлтийг 1949 оноос өмнөх байдалтай харьцуулах ёстой байв. Товчхондоо дүгнэхэд сайн эхлэл тавигдсан боловч судалгаанд хэлбэрдэх, өнгөц хандах, үйл явдлыг хэтрүүлэх эсвэл дутуу үнэлэх явдал гарч байв. "Соёлын хувьсгал"-ыг дургүйцэх үзлийн үүднээс хятад судлалд мөн дургүйцэх хандлага үүссэний улмаас хятад судлал нь Хятад орон шигээ хямралт байдалд ороход хүрсэн юм.

Хоёрдугаар үе шат: 1970-аад он

Энэ үе шатны нэг онцлог бол Хятадад "Соёлын хувьсгал" гарч, дээд удирдлагын төвшинд бүлэглэн тэмцэлдэж, олон түмэн үймэн бужигнасан эмх замбараагүй нөхцөл байдал үүссэн бол АНУ-д дээд боловсрол улмаар эрдэм шинжилгээний ажил түүний дотор хятад судлал ирмүүн хөгжиж байсан үетэй тохиож байв. Холбооны засгийн газар болон хувийн сангуудын зүгээс 1960-аад оноос эхлэн хятад судлалыг хөхүүлэн дэмжиж ирсний дүнд гарч ирсэн олон арван судалгааны газрууд, хэдэн зуун судлаачид 1970-аад оны үед Хятад орны нийгмийн бүхий л салбарыг нягтлан судалж олон тооны бүтээл туурвил гаргасан юм. Эдгээр судалгаанууд гол төлөв "Соёлын хувьсгал" гарах болсон шалтгаан, Хятадад бий болсон нөхцөл байдал, үр дагавар нөлөө, сургамжийг задлан шинжлэхэд чиглэж байв. Энэ үе шатанд мөн мэдээлэл олж авах боломж нэлээд өөрчлөгдөж ирсэн юм. Хэдийгээр "Соёлын хувьсгал"-ын үед албан ёсны хэвлэлүүдийн ихэнхи хаагдаж, гарч байсан хэдийн нийтлэлийн бодлого нь ухуулан таниулах, хэвшмэл, мэдээллийн ач холбогдлоор дутмаг байсан боловч "Улаан хамгаалагчид"-ын бий болгосон хэвлэл мэдээллийн хэрэгслүүд шинэ шинэ чухал мэдээлэл өгч байлаа. "Улаан хамгаалагчид" төв орон нутгийн удирдагчдыг илрүүлэн шүүмжлэхийн тулд янз бүрийн сонин хэвлэл, зурагт хуудас хэвлэн тарааж байсан нь 1949 оноос хойшхи хятадын удирдлага дахь бодлого боловсруулах үйл явц, фракц

бүлэглэлүүдийн тэмцэл мөн түүнчлэн улс төрийн удирдагч байсан хүмүүсийн тухай чухал мэдээлэл олж авахад ихээхэн ач холбогдолтой байсан юм. Хятад дахь хүчирхийлэл даамжирч "улаан хамгаалагчид" хөдөөд тархан 1968 оны сүүлч үеэс олон тооны иргэд Гонконгд олноор ирэх үед Америкийн эрдэмтэд тэднээс доод төвшинд коммунист дэглэмийн явуулж байсан бодлого, нөлөөллийн тухай шинэ мэдээлэл авч байлаа. Судалгааны байгууллага, судлаачдын тоо нэмэгдсэнтэй уялдан энэ үе шатанд судалгаа ерөнхийлөн дүгнэх байдлаас нийгмийн янз бүрийн салбар, бүс нутаг, хот тосгон, хүн амын янз бүрийн давхаргыг дагнан судлах хэлбэрт шилжиж байлаа. Энэ нь судалгааг нарийвчлах, урд хийсэн үнэлэлт дүгнэлтийг гүнзгийрүүлэн баяжуулахад чухал ач холбогдолтой байсан юм. Харин улс төр, социологиос бусад салбарын хувьд мэдээлэл хомс байдал хэвээр үргэлжлэн зарим тохиолдолд жишээ нь урлаг, утга зохиолын салбарт хятадын сэхээтнүүд хавчилт мөрдлөгөнд өртсөний улмаас судалгаа бараг хийгдээгүй юм. Энэ үе шатанд Америкийн эрдэмтэд судалгаа хийх явцдаа өөрчлөгдөн хувьсах Хятадын улс төрийн бодлого, нийгмийн байдлыг тодорхойлоход багагүй бэрхшээлтэй тулгарав. "Улаан хамгаалагчдын" үймээн нь хятадын удирдлага ба хятадын нийгэм хоёр урьд итгэж байсан шиг тийм нэгдэл нягтралтай биш гэдгийг 1950-аад онд хүчээр тулгасан улс төрийн хяналт "Соёлын хувьсгал"-ын үед нэлээд сулран ганхсаныг харуулж өгөв.

1970-аад онд Америкийн эрдэмтэд урьдын судалгааны ажлынхаа ажлын зэрэгцээ нийгмийн амьдралд идэхтэй оролцож байлаа. 1970-аад оны эхэн үед залуу эрдэмтэд Ази судлалын эрдэмтдийн хорооны /Committee of Concerned Asian Scholars/ ажилд идэвхтэй оролцон сургалт судалгаа, ном сэтгүүл гаргахад оролцож байв. Тэдний үйл ажиллагаа зөвхөн Азид явуулж буй Америкийн бодлого шүүмжлэхэд чиглэсэн төдийгүй нэртэй их сургуулиуд болон АНУ-ын засгийн газар, томоохон сангуудын хооронд Ази судлалын төслүүдийг хэрэгжүүлэх талаар санхүү, зохион байгуулалтын зуучийн үүргийг гүйцэтгэхэд чиглэж байлаа. Энэ үе шатны төгсгөл үрүү Америкийн хятад судлаачид Хятад-Америкийн харилцааг сайжруулах, Хятадын талаархи олон түмний мэдлэгийг дээшлүүлэхэд ихээхэн анхаарал хандуулж байв. АНУ-Хятадын харилцааг судлах үндэсний хороо /National Committee on US-China Relations/ Хятадтай хийх улс төрийн ба соёлын солилцоог голлон зохион байгуулж, Америкийн эрдэмтдийг Хятадад явуулах, хятадын эрдэмтдийг АНУ-д хүлээн авах

ажлыг хариуцаж байлаа. 1970-аад оны үеийн Америкийн хятад судлалд хэд хэдэн дутагдалтай тал ажиглагдсан юм. Нэгдүгээрт, Хятадын түүхэн болон харьцуулсан хэтийн төлвийг судлахад бага анхаарсан, хоёрдугаарт, "Соёлын хувьсгал"-ын талаархи маоист тайлбар, үндэслэлийг бараг шүүмжлэлгүй хүлээн авах буюу дутуу үнэлж байсан, гуравдугаарт, мэдээллийн бас нэг чухал эх сурвалж болох дунд шатны байгууллагын хүнд суртлын аппарат, үйлдвэр аж ахуйн газар коммунд бага анхаарал тавьж байлаа.

Гуравдугаар үе шат: 1980-аад он

Америкийн хятад судлалын гуравдахь үе шатны онцлог мөн л Хятад дахь өөрчлөлт шинэчлэлт, нээлттэй бодлоготой холбоотой бөгөөд Маогийн дараа Дэн Сяопиний удирдан эхлүүлсэн нийгэм эдийн засгийн асар өргөн цар хүрээтэй шинэтгэл АНУ-д хятад судлаачдын шинэ үе өсөж өндийхөд ихээхэн түлхэц өгсөн юм. Шинэтгэл нь 1980-аад оны хятад судлалд судалгааны чиглэл тодорхойлох, мэдээлэл олж авах, шинэ бололцоо нээх гэсэн хоёр чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Гэхдээ энэ нөхцөл байдал 1980-аад оны эхэн үеийн АНУ-ын хятад судлалд шууд нөлөөлөөгүй бөгөөд судалгааны хүрээн дэх энэхүү зогсонги байдал 1950-иад оны улс төрийн уур амьсгалаас бус эрдэм судлалын орчинд гарсан өөрчлөлтөөс шалтгаалж байв. 1980-аад оны эхэн үед хятад судлалыг дэмжих явдал эрс буурч ирсэн нь нэг талаас хүн амын хурдан өсөлт, ачааллыг их дээд сургуулиуд дааж чадахаа больсон, нөгөө талаас 1960,70-аад оны ирмүүн хөгжлийн гол түлхэц болж байсан санхүүгийн дэмжлэг буурсантай холбоотой байлаа. Томоохон сангууд Америкийн хятад судлаачдын шинэ үеийг бэлтгэн гаргахаас илүүтэй хятадаас ирсэн эрдэмтдийн шинэ үеийг сургаж бэлтгэх явдлыг дэмжих хандлагатай байлаа. Энэхүү зогсонги байдал 1980-аад оны дунд үе хүртэл үргэлжилсэн юм. Энэ үе шатны төгсгөл рүү Америкийн хятад судлалд шинэ үе гарч ирж, сургалт судалгааны ажил дотоод гадаадад нэлээд эрчимжиж ирсэн юм. Хятадад очих боломж нээгдсэний үр дүнд хятад судлалын бүхий л салбарт таатай боломж бүрдэж, урьд ихээхэн хязгаарлагдмал байсан антропологи, эдийн засаг, хүн судлал зэрэг салбарууд улс төр судлал, социологийн судалгааны адил төвшинд хүрч, урьд өмнөхөөс илүү бүх талын нэлээд бодитой статистикийн мэдээлэл олж авах, хээрийн судалгаа хийх илүү өргөн бололцоо нээгдсэн юм. АНУ-ын эрдэмтэд ч энэхүү боломжийг ашиглан судалгааг улам төрөлжүүлэн дагнасан нийгмийн амьдралын гүн рүү чиглүүлэн явуулж

байлаа. 1970-аад онд нийгмийн шинжлэх ухаанд гарсан “хувьсгалын” /behavioral revolution/ нөлөөгөөр хятад судлал нь бодлого боловсруулалтын үе шатанд /input/ төвлөрч байсан буюу удирдлагын доторхи зөрчил тэмцэл, нийгмийн янз бүрийн бүлгийн улс төрийн ашиг сонирхлыг судлах явдал зонхилж байв. Харин 1980-аад онд удирдлага болон ард түмний аль алины үйл ажиллагааны /action/ бүтцийн өөрчлөлтөнд ихээхэн анхаарал тавих болжээ. Өөрөөр хэлбэл 1970-аад онд үйл явцын өрнөлтийг голлож судалж байсан бол 1980-аад онд бүтцийн өөрчлөлтөнд ихээхэн анхаарал тавих болжээ. Тийм учраас эдийн засгийн чиглэлийн судлаачид Хятадын эдийн засгийн бүтэц бүрэлдэхүүнийг биш харин хувьчлал, төвлөрсөн зохицуулалтыг өөрчлөх зэрэг асуудалд судалгаагаа чиглүүлж, улс төр судлаачид улс төрийн үйл ажиллагаан дахь төрийн засаглал, бүс нутгийн системийн үүрэг ролийг судлахад голлон анхаарч, гадаад бодлого судалдаг эрдэмтэд олон улсын систем улс орны гадаад бодлогод хэрхэн нөлөөлдгийг ойлгохын тулд Хятадыг судалж байлаа.

АНУ-ын хятад судлаачид энэ үе шатанд Хятадыг хуучин социалист системийн орнууд, тэрчлэн Тайваньтай түүхэн өнгөрсөн үед харьцуулан судлах ажлыг нэлээд хийсэн байна. Энэ үе шатны нэг онцлог бол Хятад судлал суурь судалгаа тийш өөрчлөгдсөн, бодлого боловсруулах, олон түмэнд мэдлэг түгээх үйл явцад гүйцэтгэх үүрэг нь буурсан явдал юм. Энэ үйл явц нь хятад судлал маш гүнзгийрэн дагнан төрөлжсөн болон харьцангуй боловсрон төрөлжсөнтэй холбоотой. Нөгөөтэйгүүр мэргэжил дээшлүүлэх, хичээл заах эсвэл нийгэмд үйлчлэх төдийгээс хавьгүй өндөр шаардлага тавьдаг АНУ-ын их сургуулиудын судалгааны төвшин үүнд мөн нөлөөлжээ. Мөн түүнчлэн уламжлалт бүс нутгийн судалгаа суурь судалгааны чухал хэсэг болж байгааг харуулж байна. Вьетнамын дайн, дараа нь харилцаа сайжруулахыг эрмэлзэж байсан 1960,70-аад оныг бодвол өнөө үед хятад судлалын эрдэмтэд АНУ-ын зүгээс Хятадтай харилцах талаарх бодлого боловсруулахад бага оролцон болжээ. Үүний илрэл 1989 оны Тяньаньмэний хэрэг явдлын үед тод харагдсан юм. Мөн түүнчлэн Америк-Хятадын харилцаагаар хангалттай бүтээл гарчихсанаас бус харин цэвэр судалгааны эрэлт хэрэгцээт байдал, АНУ-ын засгийн газар ийм судалгааг дэмжих хөрөнгө дутагдалтайгаас үүдэлтэй юм. Иймэрхүү байдал нийгмийн оюуны хүрээнд ажиглагдаж байна. Хятад судлалын эрдэмтдийн бичсэн ном хэдийчинээ өргөн олонд хүрэхгүй байна, олон нийт хятадын тухай ойлголтыг мэргэжлийн бус хүмүүс, сэтгүүлчид.

цагаачид, жуулчдаас олж авах эрмэлзэл төдийчинээ их байдаг ажээ.

Америкийн судлаачид 1980-аад онд ихээхэн амжилтанд хүрсний зэрэгцээ зарим сул талууд байгааг хүлээн зөвшөөрч байна. Юуны өмнө зарим чиглэлийн судалгаа тухайлбал, Хятадын геополитикийн байдал, Маогийн дараахь үеийн Хятадын эдийн засгийн гадаад харилцаа, Хятад-Зөвлөлт, Хятад-АНУ-ын харилцааг судлах явдал орхигдсон байна. Мөн түүнчлэн нам төрийн шинэ удирдлага, засгийн газрын агентлагууд ба нам хоорондын харилцаанд гарч буй өөрчлөлт, зах зээлд шилжих төвшин, түүний үр дагавар, үнийн реформ, төв ба орон нутгийн засаг захиргаа, харилцаа гэх мэт шинэтгэлийн зарим асуудлууд бага судлагдаж байна. Хэдийгээр мэдээллийн бололцоо нэмэгдсэн боловч өмнөх үеийн түүхэн судалгааны шинэ бүтээл бараг гарсангүй. Өөр нэг асуудал бол орчин үеийн Хятадын судалгааны нэгтгэн дүгнэх, салбар хоорондын интеграцчилах үйл явц дагнасан судалгаанаасаа хол хоцрогдсон явдал юм. Хятадтай шууд харилцаа тогтсоны дунд шинэ шинэ ойлголт, мэдээлэл хүлээж авч буй боловч өнөөгийн Хятадын улс төр, эдийн засгийн системийн ерөнхий бүтэц, үйл ажиллагааны талаар шинэ сэргэг судалгаа бага байна.

Дүгнэлт ба 1990-ээд оны хэтийн төлөв

1950-аад оны сүүлчээс эхэлсэн 30 гаруй жилийн хугацаанд Америкийн хятад судлал, ялангуяа өнөөгийн хятадыг судлах ажил ихээхэн амжилтанд хүрч, олон тооны нэртэй эрдэмтэд төрөн гарсан бөгөөд АНУ-ын хятад судлаачид эдүгээ хятадын нийгмийн амьдралын бүхий л салбарын талаар ихээхэн өргөн мэдлэг ялангуяа амьдралын гүн рүү орж хийсэн ул суурьтай, сайн судалгааг хийж чадсан билээ.

Өнөөгийн хятад судлал 30 жилийн өмнөх үетэй харьцуулахад хавьгүй илүү суурь судалгааны шинжийг олоод байна. Америкийн хятад судлаачид Хятад орныг хэрхэн судлах талаар ихээхэн хичээл зүтгэл гаргасан бөгөөд эдүгээ Хятадын нийгэм улс төрийн систем, эдийн засгийг Зүүн Азийн орнууд, коммунист дэглэмтэй байсан орнуудын системтэй харьцуулан судлах чиг хандлага хүчтэй гарч ирлээ. Өнгөрсөн 30 жилийн туршлагаас үзэхэд судалгаа гүнзгийрэх тутам түүний үр дүнг боловсруулан хэвлэх, нийтийн хүртээл болгох ажил түргэн өөрчлөгдөж буй Хятад орны үйл амьдралаас ихээхэн хоцорч явдаг байна. 1989 оны 6-р сард Бээжинд болсон олон түмний тайван жагсаалыг цэргийн хүчээр нухчин дарсаны дараа Хятадад хандах америкийн хандлагад гарсан түргэн өөрчлөлт нь Америкийн хятад

судлаачид олон нийтэд Хятад дахь үйл явц урьдчилан таамаглах боломж хомс, мөн тодорхойгүй, эмзэг нөхцөл байдлыг хангалттай мэдээлж чадаагүйг харуулж байна.

1990-ээд оноос Америкийн хятад судлал хөгжлийн шинэ үе шатны зааг үед орсон юм. Иймэрхүү шинэ үе шатанд шилжих явц Хятад дахь үйл явдлын шинэ өрнөлттэй давхцах буюу тодорхойлж байдаг. 1989 оны эмгэнэлт үйл явдал, түүний дараа улс төрийн өөрөөр сэтгэгчдийг хатуу мөрдөн мөшгөж залхаан цээрлүүлж байгаа зэрэг нь томоохон асуудлыг дэвшүүлж байна. Мөн түүнчлэн 1980-аад оны төгсгөл рүү Хятадын шинэтгэл тогтворгүй байдал, гутранга үзэл, төсөв зардал ихсэх зэрэг таагүй хүчин зүйлс урьд өмнөхөөс эрс нэмэгдэж шинэтгэл эмзэг, төвөгтэй үедээ орж эхэлсэн гэж үздэг. Энэ байдал хятад судлаачдаас шинэтгэлийг дахин бүхий л талаас нь үнэлэн цэгнэх шинэтгэлийн программын алдаа дутагдал, улс төрийн бааз дахь сул тал, удирдлага доторх зөрөлдөөн, шинэтгэлээс хазайх, буцах нөхцөл бололцоог сайтар судлахыг шаардаж байна. Үүнээс гадна эдийн засгийн шинэтгэл Хятадын нийгмийн бүхий л салбар, түүний дотор судалгааны ажилд шинэ нөхцөл байдал бий болгов. Засгийн газраас гаргах хөрөнгө мөнгө багасч, хятадын судалгааны байгууллагууд эрдэмтэд хүлээн авах, материал үзэх, хээрийн судалгаа хийхэд ихээхэн өндөр хөлс мөнгө шаардах болсон ажээ. Тус орны нэртэй, чадалтай, залуу эрдэмтэд цалин хөлс доогуур улс төрийн мөрдлөгөөс зугатан саад бэрхшээл багатай, мөнгө олох ажилд шилжих нь нэмэгдэж байна.

1990-ээд онд америкийн эрдэмтдийн өмнө багагүй зорилт, асуудал тулгарч байна. Юуны өмнө судалгааны бааз, дэд бүтцээ хадгалан, дэмжин хөгжүүлэх явдал юм. Санхүүгийн бэрхшээлээс болж хятад судлалын хоёр гол байгууллага Хонконг дахь их сургуулиудад үйлчлэх төв, Вашингтон дахь хятадын сурвалж материалын төв /Center for Chinese Research Materials/ хаагдах аюул тулгарч байна. Энэ мэт шалтгаанаар хятад судлалын өндөр түвшинд хийгддэг судалгааны санхүүжилтийг хасаад байвал хятад судлал ганхан ухрахад хүрч болзошгүй хэмээн америкийн томоохон эрдэмтэд ихэд болгоомжилж байна. Цаашдын судалгааг цогц байдлаар бүх талаас явуулах шаардлагатай. Үүний тулд нийгмийн шинжлэх ухааны бусад салбарыг судалгаанд татан оролцуулах, эхний үе шатанд Ази Европын мэргэжил нэгт эрдэмтэдтэй эрдэм шинжилгээний хурал хийх, хамтын судалгаа хийх зэргээр хамтран ажиллах чухал ач холбогдолтой. Өөр нэг чухал асуудал бол судалгааны үр дүнг олон нийтэд хүргэх явдал юм. Урьд

хятад судлаачид олон нийтийн боловсролыг дээшлүүлэх, бодлого боловсруулахад оролцож байсан чухал өв, туршлага бий. Харин 1980-аад оноос судалгаа суурь шинжтэй болсны улмаас энэ уламжлалыг орхигдуулж эхэлсэн байна. 1990-ээд онд америкийн эрдэмтэд өөрийн бүтээлээ нийтэд хүртээхийн тулд урьд өмнөхөөс илүү хүч, бололцоогоо дайчлах шаардлагатай болжээ. Бас нэг асуудал эрдэмтдийн залгамж халааг бэлтгэх явдал юм. Одоогийн зонхилсон эрдэмтэд 1950-аад онд анх хятад судлалд орж ирсэн бөгөөд одоо тэд тэтгэвэрт гарч эхэллээ. Эрдэмтдийн залуу халаа гарч, хүч оюун ухаанаа хятад судлалын салбарт зориулах болно. Эрдэмтдийн эгнээ 1980-аад онд Хятадаас АНУ-д ирж суралцан, 1990-ээд онд зэрэг цол авч, 1989 оны хэрэг явдлаас хойш АНУ-д үлдэн ажиллах нөхцөл бололцоо хайх болсон хүмүүсээр сэлбэгдэх боллоо. Хятад хэлний бэрхшээлгүй, хятадын нийгмийг нарийн сайн мэддэг, өрнөдийн нийгмийн ухааны арга зүй, концепцээс суралцсан тэдгээр ажилтнууд америкийн хятад судлалын 4 дэх үе шатны чухал онцлог, өвөрмөц түлхэц болох төлөвтэй байна.

Ашигласан эх сурвалж:

1. American Studies of Contemporary China - editor David Shambaugh, Woodrow Wilson Center Press, 1993
2. И.А.Алексеев, А.А.Нагорный, А.Б.Парканский- Американские китаеведы об экономике и политике Китая: сегодня и завтра, Москва, 1989
3. <http://www.acls.org>
<http://www.ssrc.org/about/>